

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ-ДЭД БҮТЭЦ ТӨСЛИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: САГ-2026/263/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг: [Naranchimegts@audit.gov.mn](mailto:Naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: П.Чанцалдулам

Утас: 261885

Цахим хаяг: [Chantsaldulamp@audit.gov.mn](mailto:Chantsaldulamp@audit.gov.mn)

Ахлах аудитор:

Ж.Нямцэцэг

Утас: 261628

Цахим хаяг: [Nyamtsetsegj@audit.gov.mn](mailto:Nyamtsetsegj@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

Платиниум прогресс аудит ХХК-ий захирал Ж.Баяртуул

Утас: 99066015

Цахим хаяг: [platinumprogressaudit@gmail.com](mailto:platinumprogressaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	21
5.1 Албан шаардлага .....	21
5.3 Зөвлөмж.....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	24

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ ДЭД БҮТЭЦ  
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ Ж.ГАНБААТАР  
ТАНАА

2026.02.25 № 06/362  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 361 дүгээр тогтоолын дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөл”-ийн хүрээнд бий болсон нийт 59,556,693.0 мянган төгрөгийн балансын үнэтэй, 2,548,137.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг төрийн өмчит хуулийн этгээдүүдэд хүлээлгэн өгсөн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сангийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 108 дугаар тушаалаар “Монгол, Хятадын Төрийн тэргүүн нарын нэрэмжит спортын цогцолбор”-ын бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, захиалагчийн хяналт тавих эрхийг Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөлд шилжүүлж, уг төслийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэхээр эхлүүлээд байна.

### **Бусад асуудал**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлыг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>29,834,978,548.30</b>	<b>35,860,092,500.12</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>610,916,391.91</b>	<b>103,942,352.35</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>610,916,391.91</b>	<b>103,942,352.35</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>610,916,391.91</b>	<b>103,942,352.35</b>
31211	Төрийн сангийн харилцах	610,916,391.91	103,942,352.35
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>91,118,865.21</b>	<b>79,432,414.67</b>
35400	Хангамжийн материал	91,118,865.21	79,432,414.67
35410	Бичиг хэргийн материал	9,066,636.22	5,656,320.00
35420	Аж ахуйн материал	796,505.00	1,225,855.90
35430	Сэлбэг хэрэгсэл	19,061,000.00	13,579,500.00
35440	Түлш, шатах тослох материал	1,888,983.17	1,634,997.37
35470	Бусад хангамжийн материал	60,305,740.82	57,335,741.40
<b>360</b>	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>29,132,943,291.18</b>	<b>35,676,717,733.10</b>
<b>36800</b>	<b>Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад</b>	<b>29,132,943,291.18</b>	<b>35,676,717,733.10</b>
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>989,544,535.24</b>	<b>1,025,408,783.73</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>989,544,535.24</b>	<b>1,025,408,783.73</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>770,089,415.16</b>	<b>600,103,496.93</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	713,895,527.59	713,895,527.59
39204	Хуримтлагдсан элэгдэл	(142,578,692.09)	(249,861,411.53)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	316,191,427.85	286,947,917.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	(146,208,199.69)	(178,461,942.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,943,920.00	49,275,220.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,154,568.50)	(21,691,814.42)
39300	Биет бус хөрөнгө	219,455,120.08	425,305,286.80
<b>39301</b>	<b>Програм хангамж</b>	<b>2,838,000.00</b>	<b>1,771,000.00</b>
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,331,999.92)	(1,046,833.20)
39303	Бусад биет бус хөрөнгө	218,949,120.00	424,581,120.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>30,824,523,083.54</b>	<b>36,885,501,283.85</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>610,916,391.91</b>	<b>103,942,352.35</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>610,916,391.91</b>	<b>103,942,352.35</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>610,916,391.91</b>	<b>103,942,352.35</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>610,916,391.91</b>	<b>103,942,352.35</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	610,916,391.91	103,942,352.35
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>30,213,606,691.63</b>	<b>36,781,558,931.50</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>30,213,606,691.63</b>	<b>36,781,558,931.50</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>30,213,606,691.63</b>	<b>36,781,558,931.50</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	37,003,920,794.62	29,996,022,039.06
51220	Тайлант үеийн үр дүн	(6,790,314,102.99)	6,785,536,892.44
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>30,824,523,083.54</b>	<b>36,885,501,283.85</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>17,765,957,342.12</b>	<b>26,016,348,273.45</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>14,498,733,542.12</b>	<b>26,016,348,273.45</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>14,498,733,542.12</b>	<b>23,277,891,673.45</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>470,839,849.44</b>	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	470,839,849.44	-
120009	Бусад орлого	2,823,493,953.84	3,389,911,131.34
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	784,514,090.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	11,204,399,738.84	19,103,466,452.11
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	<b>2,738,456,600.00</b>
<b>1221</b>	<b>Хандив тусламж /дотоод/</b>	-	<b>2,738,456,600.00</b>
<b>12211</b>	<b>Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого</b>	-	<b>2,738,456,600.00</b>
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	2,738,456,600.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,267,223,800.00</b>	-
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,267,223,800.00</b>	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,267,223,800.00	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,126,228,505.16</b>	<b>3,072,546,390.89</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,126,228,505.16</b>	<b>3,072,546,390.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,208,240,725.91</b>	<b>2,768,606,173.30</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,489,102,686.23</b>	<b>1,597,057,052.36</b>
210101	Үндсэн цалин	1,489,102,686.23	1,597,057,052.36
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>188,540,152.39</b>	<b>193,638,945.19</b>
210201	Тэтгэврийн даатгалын зардал	126,573,728.37	128,338,588.38
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	14,891,026.87	15,959,008.25
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	15,325,491.78	16,210,102.13
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	2,886,355.04	3,011,931.50
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	28,863,550.33	30,119,314.93
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>177,145,346.51</b>	<b>195,555,489.02</b>
210304	Байрны түрээс	177,145,346.51	195,555,489.02
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>76,047,585.35</b>	<b>61,456,414.61</b>
210401	Бичиг хэрэг	10,484,262.84	10,766,616.22
210402	Тээвэр, шатахуун	4,695,871.00	3,318,985.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,485,903.24	16,611,943.65
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,147,069.02	7,723,680.52
210408	Бараа материал акталсны зардал	35,234,479.25	23,035,188.42
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>35,087,850.00</b>	<b>18,969,050.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	766,000.00	415,650.00
210604	Урсгал засвар	34,321,850.00	18,553,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>186,243,967.80</b>	<b>129,131,140.10</b>
210701	Гадаад албан томилолт	7,275,015.80	12,546,912.10
210702	Дотоод албан томилолт	174,288,952.00	112,857,622.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,680,000.00	3,726,606.00

Хөгжлийн хөтөч, дэд бүтэц төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>138,225,663.12</b>	<b>125,466,035.83</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	96,472,391.60	82,838,460.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,000,000.00	15,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	12,487,510.00	14,097,698.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	903,294.00	4,859,022.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,285,467.52	8,593,855.43
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>917,847,474.51</b>	<b>447,332,046.19</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,750,000.00	450,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	912,097,474.51	446,882,046.19
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>917,987,779.25</b>	<b>303,940,217.59</b>
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	917,987,779.25	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	911,343,779.25	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	6,644,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	303,940,217.59
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	303,940,217.59
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>13,639,728,836.96</b>	<b>22,943,801,882.56</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>20,430,042,939.95</b>	<b>16,158,264,990.12</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	20,430,042,939.95	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	16,158,264,990.12
<b>VII</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>	<b>(20,430,042,939.95)</b>	<b>(16,158,264,990.12)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>(6,790,314,102.99)</b>	<b>6,785,536,892.44</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>5,871,768,633.84</b>	<b>6,128,367,731.34</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,604,544,833.84</b>	<b>6,128,367,731.34</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,604,544,833.84</b>	<b>3,389,911,131.34</b>
120009	Бусад орлого	2,604,544,833.84	3,389,911,131.34
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	<b>2,738,456,600.00</b>
<b>1221</b>	<b>Хандив тусламж /дотоод/</b>	-	<b>2,738,456,600.00</b>
<b>12211</b>	<b>Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого</b>	-	<b>2,738,456,600.00</b>
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	2,738,456,600.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,267,223,800.00</b>	-
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,267,223,800.00</b>	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,267,223,800.00	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,256,976,517.07</b>	<b>2,710,111,100.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,256,976,517.07</b>	<b>2,710,111,100.00</b>

Хөгжлийн хөтөч, дэд бүтэц төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,345,479,400.75</b>	<b>2,406,170,882.41</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,487,966,686.16</b>	<b>1,597,057,052.36</b>
210102	Нэмэгдэл	1,487,966,686.16	1,597,057,052.36
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>188,540,152.39</b>	<b>193,638,945.19</b>
210201	Тэтгэврийн даатгалын зардал	126,573,728.37	128,338,588.38
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	14,891,026.87	15,959,008.25
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	15,325,491.78	16,210,102.13
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	2,886,355.04	3,011,931.50
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	28,863,550.33	30,119,314.93
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>173,849,808.54</b>	<b>195,555,489.02</b>
210304	Байрны түрээс	173,849,808.54	195,555,489.02
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,532,066.83</b>	<b>33,710,214.07</b>
210401	Бичиг хэрэг	6,338,325.00	5,888,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,809,260.00	3,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,904,417.83	15,995,543.65
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,480,064.00	8,826,270.42
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>57,655,750.00</b>	<b>33,859,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	350,000.00	9,739,000.00
210602	Тавилга	-	60,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,146,000.00	1,727,000.00
210604	Урсгал засвар	42,159,750.00	22,333,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>186,243,967.80</b>	<b>129,131,140.10</b>
210701	Гадаад албан томилолт	7,275,015.80	12,546,912.10
210702	Дотоод албан томилолт	174,288,952.00	112,857,622.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,680,000.00	3,726,606.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>209,940,969.03</b>	<b>222,768,641.67</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	173,457,357.73	194,653,066.24
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	12,487,510.00	14,097,698.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	903,294.00	4,859,022.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,015,807.30	9,081,855.43
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,750,000.00	450,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,750,000.00	450,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>911,497,116.32</b>	<b>303,940,217.59</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	<b>303,940,217.59</b>
<b>21311</b>	<b>Засгийн газрын дотоод шилжүүлэг</b>	-	<b>303,940,217.59</b>
<b>213112</b>	<b>Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал</b>	-	<b>303,940,217.59</b>
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	303,940,217.59
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>911,343,779.25</b>	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	911,343,779.25	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>153,337.07</b>	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	153,337.07	-

Хөгжлийн хөтөч, дэд бүтэц төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,614,792,116.77	3,418,256,631.34
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	2,512,790,637.90	3,925,230,670.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,512,790,637.90	3,925,230,670.90
2200	Дотоод эх үүсвэрээр	2,512,790,637.90	3,925,230,670.90
220001	Барилга байгууламж	1,857,182,197.02	3,328,543,315.00
222001	Тоног төхөөрөмж	-	31,944,073.39
223001	Бусад хөрөнгө	645,207,820.88	536,397,782.51
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,400,620.00	28,345,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,512,790,637.90)	(3,925,230,670.90)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	102,001,478.87	(506,974,039.56)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	508,914,913.04	610,916,391.91
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	610,916,391.91	103,942,352.35

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	37,479,981,801.74	37,479,981,801.74
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(476,061,007.12)	(476,061,007.12)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	37,003,920,794.62	37,003,920,794.62
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(6,790,314,102.99)	(6,790,314,102.99)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	30,213,606,691.63	30,213,606,691.63
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	30,213,606,691.63	30,213,606,691.63
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(217,584,652.57)	(217,584,652.57)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	29,996,022,039.06	29,996,022,039.06
19	Тайлант үеийн үр дүн	-	-	6,785,536,892.44	6,785,536,892.44
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	36,781,558,931.50	36,781,558,931.50

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>3,534,869,700.00</b>	<b>2,434,516,382.41</b>	<b>1,100,353,317.59</b>	<b>68.9</b>
12	Татварын бус орлого	3,534,869,700.00	2,434,516,382.41	1,100,353,317.59	68.9
122	Тусламжийн орлого	3,534,869,700.00	2,434,516,382.41	1,100,353,317.59	68.9
122005	Төсвөөс санхүүжих	3,534,869,700.00	2,434,516,382.41	1,100,353,317.59	68.9
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,534,869,700.00</b>	<b>2,434,516,382.41</b>	<b>1,100,353,317.59</b>	<b>68.9</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,534,869,700.00</b>	<b>2,434,516,382.41</b>	<b>1,100,353,317.59</b>	<b>68.9</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,534,869,700.00</b>	<b>2,434,516,382.41</b>	<b>1,100,353,317.59</b>	<b>68.9</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,791,500,000.00	1,597,057,052.36	194,442,947.64	89.1
210102	Нэмэгдэл	1,791,500,000.00	1,597,057,052.36	194,442,947.64	89.1
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>227,837,500.00</b>	<b>193,638,945.19</b>	<b>34,198,554.81</b>	<b>85.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	152,277,500.00	128,338,588.38	23,938,911.62	84.3
210202	Тэтгэмжийн даатгал	17,915,000.00	15,959,008.25	1,955,991.75	89.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,232,000.00	16,210,102.13	2,021,897.87	88.9
210204	Ажилгүйдлийн даатгал	3,583,000.00	3,011,931.50	571,068.50	84.1
210205	Эрүүл мэндийн даатгал	35,830,000.00	30,119,314.93	5,710,685.07	84.1
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>208,201,800.00</b>	<b>195,555,489.02</b>	<b>12,646,310.98</b>	<b>93.9</b>
210304	Байрны түрээс	208,201,800.00	195,555,489.02	12,646,310.98	93.9
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>56,214,300.00</b>	<b>33,710,214.07</b>	<b>22,504,085.93</b>	<b>60.0</b>
210401	Бичиг хэрэг	11,125,900.00	5,888,400.00	5,237,500.00	52.9
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,490,200.00	15,995,543.65	7,494,656.35	68.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,598,200.00	8,826,270.42	9,771,929.58	47.5
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>97,353,200.00</b>	<b>62,204,900.00</b>	<b>35,148,300.00</b>	<b>63.9</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,100,000.00	33,453,100.00	1,646,900.00	95.3
210602	Тавилга	4,800,000.00	4,691,400.00	108,600.00	97.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	16,953,200.00	1,727,000.00	15,226,200.00	10.2
210604	Урсгал засвар	40,500,000.00	22,333,400.00	18,166,600.00	55.1
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>268,596,200.00</b>	<b>129,131,140.10</b>	<b>139,465,059.90</b>	<b>48.1</b>
210701	Гадаад албан томилолт	14,600,000.00	12,546,912.10	2,053,087.90	85.9
210702	Дотоод албан томилолт	243,246,200.00	112,857,622.00	130,388,578.00	46.4

**Хөгжлийн хөтөч, дэд бүтэц төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	10,750,000.00	3,726,606.00	7,023,394.00	34.7
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>852,166,700.00</b>	<b>222,768,641.67</b>	<b>629,398,058.33</b>	<b>26.1</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	807,358,500.00	194,653,066.24	612,705,433.76	24.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,000,000.00	-	15,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	14,100,000.00	14,097,698.00	2,302.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,903,400.00	4,859,022.00	44,378.00	99.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	171,000.00	77,000.00	94,000.00	45.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,633,800.00	9,081,855.43	1,551,944.57	85.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>33,000,000.00</b>	<b>450,000.00</b>	<b>32,550,000.00</b>	<b>1.4</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,250,000.00	-	20,250,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,750,000.00	450,000.00	12,300,000.00	3.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	610,916,391.91		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	610,916,391.91		

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

“Хөгжлийн хөтөч дэд бүтэц” төслийг Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 196 дугаар тогтоолоор хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, Улаанбаатар хот, аймаг, томоохон суурин газрын дэд бүтцийг хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор байгуулсан. Төслийн хүрээнд Монгол Улсын хилийн боомт, аймгийн төв, нийслэлийн хот төлөвлөлтийг сайжруулах дараах 3 дэд төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- “Хилийн боомт” дэд төсөл;
- “Аймгийн төв” дэд төсөл;
- “Гудамж” дэд төсөл.

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь үйл ажиллагааны зорилгоо “Монгол Улсын хилийн боомтуудын дэд бүтэц, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээний нөхцөлийг бүрдүүлэх, нэвтрэх чанарыг сайжруулан олон улсын жишигт хүргэх, нийслэл болон аймгийн төвүүдийг хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан дэд бүтэц, авто замын оновчтой сүлжээг бий болгох, хот төлөвлөлтийн шинэ шийдлүүдийг хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Авто замын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн Газрын 2016 оны 196 дугаар тушаал, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаал, “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны дотоод журам зэрэг хууль эрх зүйн баримт бичгийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Шалгагдагч байгууллагад дотоод хяналт хариуцсан ажилтан, дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Сангийн сайдын 2022 оны 133 дугаар тушаалаар баталсан “Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам” болон Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх” журмын дагуу Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалт, эрсдэлийн үнэлгээний газраас хяналтыг жил бүр хэрэгжүүлдэг байна. Тус газраас 2024 оны төслийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, Хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр 91.9 хувьтай “Маш сайн” гэж дүгнэгдсэн бол Хяналт шинжилгээ үнэлгээний 2025 оны тайлан аудитын явцад ирээгүй.

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Хөгжлийн хөтөч дэд бүтэц” төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 2021 онд боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрддөг ба холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Хөгжлийн хөтөч дэд бүтэц” төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,060,978.2 мянган төгрөгөөр буюу 20.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	610,916.4	103,942.4	(506,974.0)
Бараа материал	91,118.9	79,432.4	(11,686.5)
Нөөцийн бараа	29,132,943.3	35,676,717.7	6,543,774.4
Үндсэн хөрөнгө	989,544.5	1,025,408.8	35,864.3
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>30,824,523.1</b>	<b>36,885,501.3</b>	<b>6,060,978.2</b>
Нийт өр төлбөрийн дүн	610,916.4	103,942.4	(506,974.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	30,213,606.7	36,781,558.9	6,567,952.2
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>30,824,523.1</b>	<b>36,885,501.3</b>	<b>6,060,978.2</b>

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, нөөцийн бараа, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Тухайлбал,

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл дэх 103,942.3 мянган төгрөг нь бусад төсөл, нөөцийн харилцах данс дахь барьцаа хөрөнгийн үлдэгдэл;
- Бараа материалын үлдэгдэл 79,432.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 11,686.5 мянган төгрөгөөр буурсан нь төслийн зохицуулагчийн 2025 оны А/08, А/23 тушаалуудаар 23,035.2 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан нь голлон нөлөөлсөн;
- Нөөцийн бараа дансны үлдэгдэл 35,676,717.7 мянган төгрөг болж өмнөх оноос 6,543,774.4 мянган төгрөгөөр өссөн нь нь 2025 оны бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийн 8,027,221.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, ашиглагч байгууллагад 6,506,311.1 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлснээс шалтгаалсан;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,025,408.8 болж өмнөх оноос 35,864.3 мянган төгрөгөөр өссөн нь батлагдсан төсвөөс 28,345.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, ТӨБЗГ-ын 2025 оны 371, 727 дугаар тогтоолуудын дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 54,717.1 мянган төгрөгийн хөрөнгийн үнийг шинэчилж, 21,714.1 мянган төгрөгөөр данс бүртгэлд тусгасан зэргээр нэмэгдэж, ТӨБЗГ-ын А1/1382, А2/2449 дүгээр тогтоолын дагуу 20,321.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасантай холбоотой;
- Өр төлбөрийн үлдэгдэл 103,942.4 мянган төгрөг нь Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын нэг жилийн дараа чөлөөлөгдөх 3 гэрээт ажлын (Барилга эрч ХХК, Ноён өндөр констракшн ХХК, Стадиум бюлдинг ХХК) чанарын баталгааны үлдэгдэл;
- Засгийн газрын хувь оролцоо 36,781,558.9 мянган төгрөг болж өмнөх оноос 6,567,952.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой.

Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөл нь дараах програмуудыг нягтлан бодох бүртгэл болон үйл ажиллагаандаа ашиглаж байна. Үүнд:

- “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн 2017 оны 880.0 мянган төгрөгийн анхны өртөг, 176.0 мянган төгрөгийн балансын дүнтэй нягтлан бодох бүртгэлийн “Acolous” программ, тайлант онд 737.0 мянган төгрөгийн лицензийн төлбөр төлсөн;
- “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн 2017 оны 440.0 мянган төгрөгийн анхны өртөг, 88.0 мянган төгрөгийн балансын дүнтэй нягтлан бодох бүртгэлийн “Acolous” программын сүлжээ, тайлант онд 264.0 мянган төгрөгийн лицензийн төлбөр төлсөн;
- Дататек ХХК-ийн 2023 оны 990.0 мянган төгрөгийн анхны өртөг 495.0 мянган төгрөгийн балансын дүнтэй Барилга, инженерийн шугам сүлжээний ажлын төсөв бодох “Estimator Pro multi” программ;
- Дататек ХХК-ийн 2023 оны 264.0 мянган төгрөгийн анхны өртөг, 132.0 мянган төгрөгийн балансын дүнтэй “Estimator Pro single” шинэчлэлтийн программ;
- Виздом софт ХХК-ийн 2023 оны 880.0 мянган төгрөгийн анхны өртөг, балансын дүнтэй “Estimator pro 4.0” программ зэрэг нийт 5 программыг ашиглагдаж байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 5,521,392.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 2.4 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 204.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20,772.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 17,987.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 61,238.0 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 184,580.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 267,983.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 32,250.0 мянган төгрөг, нийт 584,810.8 мянган төгрөгөөр тус тус бууруулж, 4,936,789.0 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн төслийг өмнөх онуудын төсвийн хязгаарт багтаан баталсан байна.

Мөн 2025 оны 7 дугаар сард тодотгол хийж батлагдсан төсвөөс байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 346.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 3,105.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 8,938.8 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 115,583.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 1,429,781.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 53,250.0 мянган төгрөг, нийт 1,611,005.3 мянган төгрөгөөр бууруулж 3,325,783.7 мянган төгрөгөөр тодотгосон байна.

Монгол, Хятадын төрийн тэргүүн нарын нэрэмжит спорт цогцолборын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 199,086.0 мянган төгрөг, Цагаандэл Уул боомтын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 10,000.0 мянган төгрөгийн төсөв тус тус нэмэгдэж батлагдсан төсөв нийт 3,534,869.7 мянган төгрөг байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийг санхүүжүүлэхээр нийт 3,534,869.7 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,738,456.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, 303,940.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,434,516.3 мянган төгрөг буюу 68.9 хувьтай байгаа нь Санхүү, төсвийн нэгдсэн удирдлагын арга хэмжээний гүйцэтгэл 28.8 хувь, Гадаад зээл тусламжаар хэрэгжих төсөл арга хэмжээний гүйцэтгэл 67.7 хувиар тус тус дутуу зарцуулсантай холбоотой буюу төсвийн хэмнэлтээр төлөвлөсөн санхүүжилт олгогдоогүйтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	70202-Санхүү, төсвийн нэгдсэн удирдлага 83112-Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	3,325,783.7	2,366,935.2	958,848.5	71.2
2	70207- Гадаад зээл тусламжаар хэрэгжих төсөл хөтөлбөр 83112-Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	209,086.0	67,581.1	141,504.9	32.3
<b>Нийт дүн</b>		<b>3,534,869.7</b>	<b>2,434,516.3</b>	<b>1,100,353.4</b>	<b>68.9</b>

Тус төсөл хэрэгжүүлэгч нэгжид 30 орон тоо баталж, 1,791,500.0 мянган төгрөгийн цалингийн зардлыг төлөвлөсөн ба тодотголоор Монгол, Хятадын төрийн тэргүүн нарын нэрэмжит спорт цогцолборын төслийг хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 12-ны 116 дугаар тушаалаар 37 болж баталсан ба тодотголоор 31 болж буурсан байна.

Тайлант онд гадаад томилолтын зардалд 14,600.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр ОХУ-д Хилийн боомтын бүтээн байгуулалтын ажилтай холбогдуулан Монгол Орос 2 улсын хилийн боомтын бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн өнөөгийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл, туршлага солилцох хуралд оролцох, БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх "Монгол, Хятадын төрийн тэргүүн нарын нэрэмжит спортын цогцолбор" барих төслийн хүрээнд 12,546.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Мөн гадаад зочин хүлээн авах зардалд 10,750.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх "Монгол, Хятадын төрийн тэргүүн нарын нэрэмжит спортын цогцолбор" барих төслийн хүрээнд Монгол улсад ирж ажиллах БНХАУ-ын зураг төслийн зөвлөх IPPR компанийн судалгааны багийг 3,726.6 мянган төгрөгөөр хүлээн авсан байна.

Тайлант онд сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардалд 12,750.0 мянган төгрөгийн 3 арга хэмжээ төлөвлөснөөс 1,850.0 мянган төгрөгөөр 2 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 15 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

1. Сангийн сайдын 2025 оны 21, 190 дугаар тушаалаар БНХАУ-ын тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Хилийн боомтын дэд бүтцийн төсөл"-ийн Монгол талын хөрөнгө /Дорноговь замын-Үүд боомт, Өмнөговь, Гашуунсухайт боомт/-д нийт 13 төсөл, арга хэмжээг 14,364,300.0 мянган төгрөгөөр баталсан байна. Гүйцэтгэлээр 12 төсөл, арга хэмжээний 11,168,100.0 мянган төгрөгийг санхүүжүүлсэн бөгөөд 6 төсөл, арга хэмжээний ажил бүрэн дуусаж, комисс 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр ажилласан тул 2,598,100.0 мянган төгрөг, хүчингүй болсон 1 төсөл, арга хэмжээний 442,000.0 мянган төгрөгийг 2026 онд тус тус санхүүжүүлэхээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгажээ.
2. Мөн Сангийн сайдын 2025 оны 190 дугаар тушаалаар БНХАУ-ын тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Ерөнхийлөгч нарын спорт цогцолбор төсөл" /Улаанбаатар/-д 3,553,700.0 мянган төгрөгийг баталсан боловч тайлант онд санхүүжилт хийгдээгүй, 2 төсөл, арга хэмжээний 2,781,400.0 мянган төгрөгийг 2026 онд санхүүжүүлэхээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилт явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	БНХАУ-ын тусламжаар хэрэгжиж буй "Хилийн боомтын дэд бүтэц төсөл"-ийн Монголын талын хөрөнгө /Дорноговь, Замын-Үүд боомт, Өмнөговь, Гашуунсухайт боомт/	2019-2025	100	100	14,364,300.0	11,168.1
2	БНХАУ-ын тусламжаар хэрэгжиж буй "Ерөнхийлөгч нарын спорт цогцолбор төсөл"-ийн Монголын талын хөрөнгө /Улаанбаатар/		100	-	3,355,700.0	-
<b>ДҮН</b>					<b>17,720.0</b>	<b>11,168.1</b>

**5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд нийт 24,820,638.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 23 бараа, ажил үйлчилгээний 17,286,488.2 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөж дараах байдлаар хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Гадаад зээл тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалтын хүрээнд он дамжиж ирсэн 2 ажил, 2 үйлчилгээнд 6,990,108.8 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж, шинээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 5 ажил, үйлчилгээг зарлаж, 3 тендер амжилттай болж нийт 5,065,053.3 мянган төгрөгийн гэрээ хийгдэж 4,086,136.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон;
- Урсгал зардлын хүрээнд шууд худалдан авалтаар 13 төрлийн 180,373.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг, харьцуулалтын аргаар 1 үйлчилгээнд тендер зарлаж, 59,500.0 мянган төгрөгийн гэрээ хийж 29,750.0 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл хэрэгжүүлэгч нэгж, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсөл хэрэгжүүлэгч нэгжийн дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой шатах тослох материалыг данс бүртгэлд тусган, зарцуулж байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Платинум прогресс аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор Н.Номин-Эрдэнэ, Э.Туяасайхан нар гүйцэтгэж, захирал Ж.Баяртуул анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Нямцэцэг, аудитын менежер П.Чанцалдулам, Газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны аудит хийсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 24,556,271.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 245,562.7 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн захирагчийн төсвийн хэмнэлт, зарцуулалтад хяналт тавьж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хэрэгжилтэд Сангийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж, үнэлгээ хийж ажилласан байна. Мөн аудитаар хуулийн хэрэгжилттэй хүрээнд хязгаарласан заалтуудтай холбоотой зөрчил илрээгүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант оны шилэн дансны цахим хуудсыг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 169, хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна. Мөн шилэн дансанд мэдээлсэн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 6,693,262.4 мянган төгрөгийн 20 орлогын, 4,249,862.2 мянган төгрөгийн 48 зарлагын гүйлгээг, тулган шалгахад тохирч байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитын хугацаанд Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, гадаад, дотоод орчин, хяналтын талаар ойлголт олж, аудитын урьдчилсан судалгааны болон төлөвлөлтийн үе шатны ажлуудыг гүйцэтгэж, төлөвлөгөө, хөтөлбөрийг батлуулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Завсрын аудитад төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хамруулж, урсгал зардал, нэмэлт санхүүжилтийн данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн 28,124.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 21,985.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	28,124.8	2	28,124.8	100.0
Зөвлөмж	1	21,985.0	1	21,985.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>50,109.8</b>	<b>3</b>	<b>50,103.6</b>	100.0

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

1. Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны [finperform.mof.gov.mn](http://finperform.mof.gov.mn) сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
2. Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ сайттай уялдуулах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 226,861.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулав.

УСНББОУС 3.46-д "... Тайлант үед илрүүлсэн уг тайлант үеийн боломжит алдааг тухайн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө засварладаг", УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг. Шаардлагатай тохиолдолд бусад нэмэлт тодруулгын хамтаар УСНББОУС-ыг даган мөрдөх нь үнэн зөв толилуулгад хүргэх байдлаар санхүүгийн тайланд тусгах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй дараах ажил гүйлгээг аудитын явцад залруулав. Үүнд:

- Шалгагдагч байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн өмнөх оны үзүүлэлтийг аудит хийгдсэн дүнтэй тулган шалгахад биет бус хөрөнгийн дүн 226,861.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байсныг тодруулахад тус нэгжид 3 газар эзэмших эрх байсан бөгөөд зориулалтаар нь үнэлгээнд өөрчлөлт оруулсан байна. Гэсэн хэдий ч 2025 оны 7 дугаар сард 3 газрыг нэгтгэн "9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц"-ны зориулалтаар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон байгаад дахин үнэлгээг хийлгэж, аудитын тайланд тусгуулав.

Аудитаар нийт 94,579.9 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд, 57,789.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 36,790.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 94,579.9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 150,982.8 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

#### 1. Гадаад албан томилолттой холбоотой

**Илрүүлэлт:** Тухайн байгууллагад ажилладаггүй албан хаагчийн гадаад албан томилолтын зардалд 1,827.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Батлагдсан төсвөөс бусад байгууллагын албан хаагчийн албан томилолтын зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 1. Албан томилолтын нөхөн олговортой холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Цалингийн зардлаас албан томилолтоор ажилласан хугацаанд цалин, томилолтын мөнгөтэй давхардуулан 7 хоногийн амралтын өдөр ажилласны цалин 55,961.6 мянган төгрөгийг нэмж олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"; мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын Хоёр. Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр...2.2.Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.1. унааны зардал; 2.2.2. байрны зардал; 2.2.3. хоолны зардал... гэсэнтэй, мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан "Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөл хэрэгжүүлэх нэгжийн албан томилолтын журам"-ын 5.6-д "Бүх нийтээр амрах, тэмдэглэлт өдрүүдэд албан томилолтоор ажилласан тохиолдолд ажилласан өдрөөр тооцож цалинг олгоно" гэсэн заалт нь холбогдох хууль тогтоомжид нийцээгүй зөрчлийг таслан зогсоож, журмын заалтыг хуульд нийцүүлэн өөрчлөн батлуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Шатахууны зардалтай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлант онд албан томилолтод зарцуулсан 32,045.5 мянган төгрөг, картаар олгосон 3,000.0 мянган төгрөг, нийт 35,045.5 мянган төгрөгийн шатах тослох материалыг данс бүртгэлд тусгалгүй, шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Албан томилолтоор болон бусад үйл ажиллагаанд н шатах тослох материалыг зарцуулахдаа данс бүртгэлд тусгаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу зарцуулж, тайлагнаж байх.

#### 2. Урсгал засварын зардалтай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Урсгал засварын зардлаас авто машин угаалгад нийт 1,745.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Урсгал засварын зардлыг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулж байх.

Дээрх аудитын шийдвэр, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2025 оны санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдлийг 2024 оны аудит хийсэн байдлын тайлангийн эцсийн үлдэгдэлтэй тулган шалгахад 226,861.1 мянган төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь аудитын тайлан баталгаажснаас хойш газрын үнэлгээг тухайн дүнгээр бууруулж, ЗГ-ын хувь оролцоог залруулсан байна.	1	226,861.1			1	226,861.1	1	226,861.1				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>226,861.1</b>			<b>1</b>	<b>226,861.1</b>	<b>1</b>	<b>226,861.1</b>				

Хөгжлийн хөтөч, дэд бүтэц төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд албан томилолтод зарцуулсан 32,045.5 мянган төгрөг, картаар олгосон 3,000.0 мянган төгрөг, нийт 35.045.5 мянган төгрөгийн шатах тослох материалыг данс бүртгэлд тусгалгүй, шууд зардалаар тайлагнасан байна.	1	35,045.5					1	35,045.5				
Цалингийн зардлаас албан томилолтоор ажилласан хугацаанд цалин, томилолтын мөнгөтэй давхардуулан 7 хоногийн амралтын өдөр ажилласны цалин 55,961.6 мянган төгрөгийг нэмж олгосон байна.	1	55,961.6			1	55,961.6						
Тухайн байгууллагад ажилладаггүй албан хаагчийн гадаад албан томилолтын зардалд 1,827.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	1,827.8			1	1,827.8						
Урсгал засварын зардлаас зориулалт бусаар машин угаалганы хөлсөнд 1,745.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна	1	1,745.0					1	1,745.0				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>94,579.9</b>			<b>2</b>	<b>57,789.4</b>	<b>2</b>	<b>36,790.5</b>	-	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 376/А0150061

Улаанбаатар хот

САГ-2026/063/НА-СТА-Тцз

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан “Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөл хэрэгжүүлэх нэгжийн албан томилолтын журам”-ын 5.6-д “Бүх нийтээр амрах, тэмдэглэлт өдрүүдэд албан томилолтоор ажилласан тохиолдолд ажилласан өдрөөр тооцож цалинг олгоно” гэж туссаны дагуу тайлант онд албан хаагчдад 55,961,583.19 (тавин таван сая есөн зуун жаран нэгэн мянга таван зуун наян гурван төгрөг арван есөн мөнгө) төгрөгийн цалин нэмж олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах,” Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын Хоёр. Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр...2.2.Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.1. унааны зардал; 2.2.2. байрны зардал; 2.2.3. хоолны зардал... гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөл хэрэгжүүлэх нэгжийн албан томилолтын журам”-ын 5.6-д “Бүх нийтээр амрах, тэмдэглэлт өдрүүдэд албан томилолтоор ажилласан тохиолдолд ажилласан өдрөөр тооцож цалинг олгоно” гэсэн заалт нь холбогдох хууль тогтоомжид нийцээгүй зөрчлийг таслан зогсоож, журмын заалтыг хуульд нийцүүлэн өөрчлөн батлуулах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban Shaardlaga\2026\0125 SAG-64.Docx

1526180808

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн зохицуулагч Ж.Ганбаатар, ахлах нягтлан бодогч Ч.Бадамжав нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ПЛАТИНИУМ ПРОГРЕСС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ

Ж.БАЯРТУУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 377/20150061

Улаанбаатар хот

САГ-2026/263/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд тухайн байгууллагад ажилладаггүй албан хаагчийн гадаад албан томилолтын зардалд 1,827,763.50 (нэг сая найман зуун хорин долоон мянга долоон зуун жаран гурван төгрөг тавин мөнгө) төгрөгийг зарцуулсан байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тус төслийн нэгжид ажилладаггүй албан хаагчийн томилолтын зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн зохицуулагч Ж.Ганбаатар, ахлах нягтлан бодогч Ч.Бадамжав нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ПЛАТИНИУМ ПРОГРЕСС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ  
Ж.БАЯРТУУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-64.Docx

1526180810